



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 01/42

Улаанбаатар хот.

Хот хоорондын ачаа тээврийн талаар  
авах арга хэмжээний тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Зам, тээврийн сайдын 2013 оны 77 дугаар тушаал, Зам, тээврийн сайдын 2015 оны 327 дугаар тушаал, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын /хуучин нэрээр/ сайдын батласан 2009 оны "Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм"-ийн 2.2, 2.4, 2.5, 2.6, 2.7 дахь заалт, мөн сайдын 2011 оны 301 тушаалаар батласан "Тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам"-ын 2.2, 2.3, 2.19, 2.20, 2.21 дэх заалт, "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 4.1.3, 4.1.5, 6.11 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хот хоорондын ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тээвэрлэлтийн үйл ажиллагааг бүртгэлжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улаанбаатар хотын "Зорчигч тээврийн төв" болон аймгийн "Автотээврийн төв", орон нутгийн хяналт шалгалтын цэгээр дамжуулан зохион байгуулахыг Тээвэр зохицуулалтын газар /Ж.Энхбат/-д үүрэг болгосугай.

2. "Тээвэрлэлттэй холбогдсон баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам"-ын дагуу холбогдох маягт, бичиг баримтуудыг хэвлүүлэх, борлуулах ажлыг зохион байгуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ш.Баяраа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээвэр хариуцсан дэд захирал /Д.Батбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Н.ПУНЦАГ



000000181